



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдөр
Хурал хуралдсан газар: Монголын Мянганы сорилтын сан, “Туул” хурлын танхим

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлаар дор дурдсан 9 асуудлыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Монголын МСС-ийн 2021.04.01-нээс 2022.03.31-ний хооронд хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг Удирдах Зөвлөлийн гишүүд хэлэлцэж батлав.
2. Монголын МСС-ийн 2021 оны 2 дугаар улирлын санхүүжилтийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлав.
3. Монголын МСС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийх зөвлөх компанийн сонгон шалгаруулалтын дүнтэй танилцсаны үндсэн дээр аудит хийх зөвлөх компанитай гэрээ байгуулахыг зөвшөөрөв.
4. Монголын МСС болон Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны хооронд байгуулах “Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ”-ний төсөлтэй танилцаж, Удирдах Зөвлөлийн гишүүдээс бичгэн зөвшөөрөл авсны үндсэн дээр батлахаар шийдвэрлэв.
5. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний зардлыг бүрэн нөхөхөд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Удирдах Зөвлөлийн гишүүд хэлэлцэж батлав.
6. Баруун эх үүсвэрийн төслийн цахилгаан хангамжийн талаар танилцуулав.
7. Гэрээний удирдлага, менежментийн аудит, Бага үнийн дүнтэй худалдан авалтын аудитын дүн болон дотоод аудитын үйл ажиллагааны 2020 оны тайланг танилцуулав.
8. Монголын МСС-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.
9. МСК-ын Дэд ерөнхийлөгчөөс Удирдах Зөвлөлийн даргад ирүүлсэн захидлын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН